



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 596

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 128,500,000.00 (нэг зуун хорин найман сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 128,350,186.88 (нэг зуун хорин найман сая гурван зуун тавин мянга нэг зуун наян зургаан төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хурумтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.
2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, "Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Чинбат, "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Саранжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;
 - 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002649



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**"Эрчим хүчиний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансаас
"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн балансад шилжүүлэх хөрөнгө**

Д/Д	Автомашины төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Автобус Хьюндай Аэро Сити", суудлын, 44-89 УНЧ	2011	57,555.00	128,500,000.00	128,350,186.88	149,813.12
				128,500,000.00 (нэг зуун хорин найман сая найман сая таван зуун мянган)	128,350,186.88 (нэг зуун хорин найман сая гурван зуун тавин мянга нэг зуун наян зургаан төгрөг найн найман мөнгө)	149,813.12 (нэг зуун дөчин есөн мянга найман зуун арван гурван төгрөг арван хоёр мөнгө)

НИЙТ ДҮН: